

ХРИСТИТГЭЛИЙН ДЭЛГЭРЭЛТ: ҮЕЧЛЭЛ БА НЭРШЛИЙН АСУУДЛУУД

Г.Түмэнбаяр

Товч утга: Түүхийн урт хугацаанд Монгол нутагт маань олон шашин шүтлэг түгэн дэлгэрч, заримдаа зэрэгцэн оришиж, онол сургаалаа дэлгэрүүлж байсан билээ. Тэдний нэг бол яах аргагүй МЭВІІ зуунаас эхлэн дэлгэрч байсан Христитгэл мөн юм. Эдүгээ судлаачдын дунд Христитгэл Монгол нутагт хэдэнтээ дэлгэрсэн талаарх байр суурь харилцан адилгүй байна. Энэхүү судалгааны өгүүлэлд Христитгэлийн дэлгэрэлтийг долоон шалгуураар шүүн тунгааж, хоёронтаа дэлгэрсэн болохыг өгүүлэхийн сацуу зарим нэг маргаантай буй нэр томъёоны талаар санал дэвшүүлжээ.

Түлхүүр үг: Христитгэл, дэлгэрэлт, үечлэл, оролдлого, Библийн орчуулга, Несторчууд,

Оршил

Хорьдугаар зууны төгсгөлөөс буюу 1990 оноос хойш Монгол Улсад Христитгэл дэлгэрч, эдүгээ хүн амын тодорхой хувийг эзлэхүйц хэмжээнд хүрсэн нь няцаах аргагүй түүхэн үзэгдэл мөн юм.¹ Уг түүхэн үзэгдлийг нэг талаас жам ёсны, зайлшгүй үзэгдэл байсан гэж үзэх нэг хэсэг байхад нөгөө хэсэг нь тухайн түүхэн цаг үеийн сод [феномен] үзэгдэл гэж үзсээр ирсэн юм. Эхний хэсгийнхэн үүнийг нотлохын тулд Христитгэлийн дэлгэрэлтийг аль МЭ VII-VIII зуунаас эхлүүлэн тооцсоор ирсэн байдаг. Харин нөгөө тал нь өмнөх үеийн дэлгэрэлтээс өнөөгийн дэлгэрэлтийн хооронд түүхэн уламжлал байгаагүй тул 1990 оноос тооцох ёстой гэсэн байр суурьтай байсаар ирлээ.

Аль нь ч байлаа гэсэн түүхэн мөн чанарт үзэгдэл мөнийн учир эрт орой нэгэн цагт түүхчдийн зүгээс зохин ёсны судалгааг хийх нь дамжиггүй байсан. Ялангуяа 1990 оноос хойшхи дэлгэрэлт нь хориодхон жилийг хамаарч байгаа тул “нэн шинэ түүх” гэж тооцогдох нь зүй. Тиймдээ ч түүхчдийн зүгээс дорвитой, дэлгэрэнгүй цогц судалгааг өнөөг хүртэл хийгээгүй байдалтай байна. Харин сүүлийн үеэс судлаач эрдэмтдийн дунд

1. Хамгийн сүүлд 2010 онд Монгол Улсын Үндэсийн Статистикийн Хорооноос зохион байгуулсан тооллогын үр дүнд 15-аас дээш насны хүн амын дунд Христэд итгэгчдийн тоог 41,117 буюу 2,1%-тай гэж дүгнэжээ. Эх сурвалж: http://www.toollgo2010.mn/doc/Main%20results_20110615_to%20EZBH_for%20print.pdf [2013-11-7]

энэхүү сэдэв эрчимтэй хэлэлцэгдэн судлагдаж эхлээд байна. Дөнгөж эхлэл төдий байгаа тул нэршил, түүх бичлэг болон үечлэлтэй холбоотой асуудлууд нэн тэргүүнд хэлэлцэгдэж байгаа юм.

Энэхүү нийтлэлээр Христитгэлийн дэлгэрэлтийг тодорхойлоход нэн шаардлагатай үечлэл хийгээд зарим нэг нэршилтэй холбоотой асуудлуудыг хөндөх болно.

1. Дэлгэрэлтийн үечлэл ба шалгуур

Түүхийн ямар ч үзэгдэл тодорхой он цагийг хамарсан байдаг. Хэдий чинээ урт цаг үеийг хамрах тусам, үүнийг цаг хугацааны хэмжээст авч үзэн, хөгжлийн үе шат, тэдгээрийг холбосон уламжлалд нь авч үзээд үеүдэд хуваан судалдаг. Энэхүү түүхийн шинжлэх ухааны “түүхэн үечлэлийн арга зүй”-г Христитгэлийн дэлгэрэлт дээр авч үзэхэд буруудах зүйлгүй. Тэр тусмаа Христитгэл дэлгэрэх гэж оролдсон, аль эсвэл дэлгэрсэн эсэх, эсвэл хэт дэлгэрсэн эсэхийг шийдвэрлэхэд энэхүү үечлэлийн асуудлыг ярихаас өөр аргагүй билээ.

Нэгэнт дэлгэрэлтийн түүхийг судлаж буй болохоор судлаачид үечлэлийн асуудлыг хөндсөөр ирсэн байдаг. Жишээлбэл, судлаач Д.Сэрдарам Христитгэлийн дэлгэрэлтийн үечлэлийг дөрвөн үе шатаар авч үзжээ. Тэрээр энэ тухай өгүүлэхдээ: “Христийн шашны Монгол дахь дэлгэрэлтийн түүхийг дөрвөн үед хувааж болно...” гээд

- 1) Монголын эртний улсуудын үе (МЭ555-840),
- 2) Их Монгол улсын үе (XIII-XIV),
- 3) “Их тоглоом”-ын үе (XIX-XX зууны эхэн),
- 4) Орчин үед буюу 1990 оноос хойш гэж авч үзжээ.²

Шашин судлаач Ж.Пүрэвдорж 1990 оноос хойшхи дэлгэрэлтийн талаар таниулцахдаа үечлэлийн асуудлыг цухас дурдсан байна. Тэрээр 1990 оноос хойшхи дэлгэрэлтийг Монголын түүхэн дэх гурав дахь дэлгэрэлт гэж үзээд, уг гурав дахь дэлгэрэлтийгээ бас дотор нь гурван үе шатаар дэлгэрсэн гэж дүгнэсэн байх юм. Түүний өгүүлсэнийг иш татвал:

“1991 оны хувьсгалтай яг зэрэгцэн эхэлсэн оюун санааны өөр нэг хувьсгал бол христ-итгэлийн хувьсгал юм. Христийн тухай мэдээ буюу евангел Монгол нутаг дэвсгэрт гурав дахь удаагаа тархсан бөгөөд үүнийг бид христийн шашны гурав дахь дэлгэрэлт гэж хэлж болох юм... Монгол дахь христийн шашны 20 жилийн хөгжлийг цаг хугацааны хувьд 3 ангилж болох юм. Үүнд: 1991-1995, 1996-2005, 2006-өнөөг хүртэл хэмээн авч үзнэ.”³

2. Д.Сэрдарам, “Монгол дахь Христийн шашны дэлгэрэлтийн түүхийн асуудал: орчин үеийн жишээн дээр” Монгол дахь шашны судалгааны өнөөгийн нөхцөл байдал. Ред. Л.Алтанзаяа (Улаанбаатар: МУБИХ, 2008), 15-18.

3. Пүрэвдорж Жамсран, “Орчин үеийн соёлын болон шашны төрх: Сүүлийн 20 жилд Монголд хөгжсөн Христийн шашны хөгжил,” Социализмын дараах Монголчууд: улс төр, эдийн засаг, шашин. Ред. Брюс М. Кнафт, Ричард Таупиер (Улаанбаатар: Адмон, 2012), 144-145.

Гадаадын судлаачдаас Христитгэлийн дэлгэрэлтийн түүхийн талаарх чамбай судалгаа хийсэн хүн бол Шинэ Зеландын судлаач Хью Кемп. Тэрээр Христитгэлийн дэлгэрэлтийн түүхийг МЭVII-VIII эхлүүлэн авч үзсэн байдаг.⁴ Харин үечлэлийн асуудлыг яг тусгайлан хөндсөн нь үгүй. Гэхдээ тэрээр Христитгэлийн дэлгэрэлтийг Монголын түүхийн үечлэлд тохируулсан байдаг. Түүний бүтээлд хавсралт хэлбэрээр “Цаг хугацааны товчоон” гэсэн сэдэв дор үечлэлийг дүрслэн харуулжээ. Үүнийг сийрүүлбэл:

1. Харилцаа тогтоож эхэлсэн үе буюу Эзэнт гүрний өмнөх үе (МЭ600-1200)

2. Дипломат харилцааны үе буюу Эзэнт гүрний үе (1200-1368)

3. Харанхуй үе буюу Эзэнт гүрний дараах үе (1368-1750)

4. Илгээлтийн шинэ үе буюу Орчин цагаас өмнөх үе (1750-1911)

5. Чуулган байгуулагдсан үе буюу Орчин үе (1990-өнөөг хүртэл)

“ИнтерСиПи” сургалтын төвийн багш, БНСУ-ын судлаач И Сон Гинь түүхийг таван хэсэгт авч үзсэнийг доор сийрүүлбэл:⁵

- 1-р үе (МЭ635-1206) Чингис хааны гарч ирэх үеэс өмнөх үе

- 2-р үе (1206-1368) Монголын цаг үе

- 3-р үе (1368-1765) Монголын бага хаадын үе

- 4-р үе (1765-1991) Манж Чин улсын дарлал ба социализмын үе

- 5-р үе (1991-2011) Ардчиллын үе гэж авч үзсэн байна.

Дээрх дотоод, гадаадын судлаачдын дэвшүүлж байгаа үечлэлээс бид дараах дүгнэлтүүдийг хийж болж байна. Үүнд:

Нэгд, Үечлэлийн үе шатууд харилцан адилгүй байна. Ихэнхдээ гурав, тав гэсэн үеийг дамнасан гэсэн байдалтай байна. Ингэх бүртээ үе болгоныгоо “дэлгэрэлт” гэж авч үзжээ.

Хоёрт, Гадаадын судлаачдын хувьд дэлгэрэлтийг шууд Монголын түүхийн үечлэлтэй холбон авч үзсэн байна.

Гуравт, Цөөн хэдэн судлаачид энэ асуудлыг хөндсөн нь уг асуудлыг нэг мөр шийдэхэд улам төвөгтэй болгож байна.

Дөрөвт, Эдгээр судлаачид маань яг ямар шалгуураар дэлгэрэлтийн үечлэлийг авч үзэж байгаа нь маш бүдэг байна. Тийм тодорхой шалгуургүйгээсээ болоод Монголын түүхийн үечлэлтэй холбосон болов уу. Цаашилбал, тодорхой шалгуургүй учраас үе шат болгоноо дэлгэрэлт гэж үзсэн бололтой.

Эндээс Христитгэлийн дэлгэрэлтийг үнэхээр дэлгэрэлт мөн байсан эсэх, мөн бол ямар үе шатыг туулсан гэдэгт зохих шалгууруудыг зайлшгүй тавих ёстой нь илт байна.

4. Хью Кемп, Түүхийн балархай жимээр (Улаанбаатар: МТӨС, 2009), 455.

5. И Со Гинь, Монголын Христитгэлийн түүх, Хичээлийн материал. (Улаанбаатар: InterCP, 2010)

Иймэрхүү шалгуургүйгээр үечлэх гэсэн чармайлт бусад түүхийн үзэгдлийг үечлэх асуудлууд дээр түгээмэл гардаг. Жишээ болгон өгүүлбэл, орчин үеийн Монголын түүхийн үечлэлийг хөндсөн бүтээлдээ Ч.Болбаатар, Д.Мөнх-Очир нар энэ мэт дутагдлыг дурдаад:

“Бидний хувьд шинэ үеийн түүхийн үечлэлийн асуудлаар арай өөр саналтай байгаа бөгөөд шалгуур үзүүлэлтийн дифференциацичлалгүйгээр үечлэлийг нэгдсэн байдлаар хийх, түүнд нийгмийн харилцааны олон талыг хамаатуулах боломжгүй гэж үзлээ. Тухайлбал, XX зууны Монголын түүхийг үечлэхэд түүхэн цаг үе тус бүрт оршин тогтнож байсан улс төрийн дэглэм, эдийн засгийн харилцаа, түүгээр зогсохгүй тухайн цаг үе дэх нийгмийн доминант соёл, үнэт зүйлүүдэд гарсан шилжилтүүд тэр бүр хоорондоо давхцдаггүй. Манай орны олон улсын статус ч тэр бүх шалгуураас өөр учир шалтгаанаар буюу хөндлөнгийн голдуу хүчин зүйлийн эрхээр өөрчлөгдөн хувьсаж ирсэн байна. Иймээс бид XX зууны Монголын түүхийг ойролцоогоор арав арван жилээр (үечлэлийн нарийвчлалыг хамгийн бодитой гаргах үүднээс) хувааж, улс төрийн дэглэм, эдийн засгийн харилцаа, олон улсын статус, нийгмийн доминант үнэт зүйл, нийгмийн доминант соёл гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрээр ангилав” гэж өгүүлжээ.⁶

Христигэлийн дэлгэрэлтийг тусгайлан судалж буй судлаачийн хувьд дээрхтэй санал нэг байгаа бөгөөд ерөөс үечлэлийг ийм олон янзаар үзэж буй нь шалгуур үзүүлэлтгүйгээс болсон гэж зориглон дүгнэх байна. Иймд үечлэхээс өмнө түүхэн цаг үедээ дэлгэрсэн нь жинхэнэ утгаараа дэлгэрэлт байж чадав уу, аль эсвэл оролдлого чармайлт байв уу? гэдэгт хариулах ёстой гэж үзэж байгаа болно. Хэрэв үнэхээр дэлгэрэлт мөн бол хэдэнтээ давтагдсан байж болохыг цаг хугацааны хэмжээст авч үзээд, үечлэх ёстой гэж үзлээ. Үүний дагуу дараах шалгуур [criteria]-уудаар дэлгэрэлт мөн, биш байсан гэж авч үзэхээр санал болгож байна. Эдгээр нь:

Нэгд, гаднаас буюу хилийн чанадаас зориудын дэлгэрүүлэлтийг [илгээлт] хийсэн эсэх. Энэ тохиолдолд урьд өмнө нь Христигэл огт дэлгэрч байгаагүй, эсвэл дэлгэрч байсан бол он удаан хугацаанд мартагдан, алга болсон байх нөхцөлд гаднаас дэлгэрүүлэлт хийсэн байх.

Хоёрт, тодорхой түүхэн урт он жилүүдийг элээсэн эсэх

Гуравт, Монгол хэл дээр ном судраа орчуулан хэрэглэж байсан, урлаг соёл, ахуй соёл, зан заншилд нь Христигэлийн үзэл санаа тусгалаа олсон эсэх

Дөрөвт, Төр засгийн зүгээс Христигэлийн талаар тусгайлан эерэг болон сөрөг бодлого явуулсан, хууль цааз тогтоосон эсэх

Тавд, хүн амын тодорхой хувийг эзэлсэн эсэх

6. Ч.Болдбаатар, Д.Мөнх-Очир, “Монголын ойрхи үеийн түүхийн үечлэлийн асуудалд.” Хэцүү өрөг, уран нүүдэл: Монголын түүхийн сэдвүүд (Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2011), 19-20.

Зургаад, Христитгэлийг хүлээн авсан, тухайн үедээ хүлээн зөвшөөрөгдөж чадсан түүхэн биет хүн, төлөөлөгчид байсан эсэх

Долоод, тухайн түүхэн оршин байсан улс гүрнийхээ хил хязгаарынхаа хүрээнд газар бүрт жигд тархсан байсан эсэх

Эдгээр шалгууруудыг тавиад, өмнөх судлаачдын дэвшүүлсэн үечлэлүүдийг эргэн шүүж үзээд Христитгэлийн дэлгэрэлтийн үндсэн хоёр үе байжээ гэсэн дүгнэлтэд хүрээд байна. Энэ хоёр түүхэн дэлгэрэлтүүдийг холбосон, дэлгэрүүлэх гэж чармайсан оролдлогын зурвас үе байжээ гэж бас дүгнэв. Хоёр дэлгэрэлтийн хооронд шууд дамжигдсан түүхэн өв уламжлал байхгүй ч, дундын зурвас үеэр сулхан холбогдож болно гэж үзэж байна. Товчхондоо, Монголд Христитгэл хоёронтаа дэлгэрсэн бөгөөд ингэхдээ түүхийн гурван үе шатуудыг туулжээ гэж дүгнэлээ. Үүнийг дараах байдлаар өгүүлбэл:

1. Анхны дэлгэрэлтийн үе (МЭVII-XIV зуун)

2. Дэлгэрүүлэх гэсэн оролдлогын зурвас үе буюу XVIII-XX зууны эхэн.

Протестант болон Католик илгээлтийн байгууллагуудын Монголд нэвтрэн орж ирэх гэсэн оролдлогын үе.

3. Хоёр дахь дэлгэрэлтийн үе буюу 1990 оноос өнөөг хүртэл.

1.1 Анхны дэлгэрэлтийн үе (МЭVII-XIV зуун)

Анхны дэлгэрэлтийн үеийг МЭVII-XIV гэж авч үзлээ. Сири, Персийн нутгаас Лалынхны түрэлтээс болж шахагдсан Зүүний чуулганыхан Торгоны замаар дамжин Төв Ази руу орж иржээ. Тэд зөвхөн Төв Ази бус бас Дундад Ази, Энэтхэгийн хойд нутгууд руу шахагдан ирсэн байдаг. Бас МЭVII-VIII зууны үед Хятадад амжилт олоод байсан Христийнхэн Хятадын Тан улсын сүүл үеийн хаадуудын явуулсан шахалт, хавчлагын улмаас говь руу, Цахар, Ордосын нутгууд руу түрэгдэн орж ирсэн байдаг. Тэдний нөлөөгөөр энэ хавиар нутаглаж байсан монгол-түрэг овгууд тэр дундаа Онгуд [Өнгүд] овог Христитгэлийг хүлээн авсан бололтой. МЭXI зуун гэхэд Хэрэйд аймгийн дийлэнх нь хэдийнээ Христийнхэн болсон байв.

Судлаачдын санал болгодогчлон Их Монгол Улсын үе буюу XIII-XIV зууныг тусад нь үе гэж авч үзэх нь тун боломжгүй юм. Харин үүнийг анхны дэлгэрэлтийн үргэлжлэл гэж үзэв. Өөрөөр хэлбэл, “*гаднаас буюу хилийн чанадаас зориудын дэлгэрүүлэлтийг [илгээлт] хийсэн эсэх*” гэсэн шалгуурт нийцэхэд учир дутагдалтай. Уг шалгуураар гаднаас зориудын дэлгэрүүлэлт хийж байхад тухайн улс оронд Христитгэл огт байгаагүй, байсан бол аль эрт байгаад тасалдсан, ерөөс Христитгэлийн ямар нэгэн институци хэлбэржээгүй байх ёстой. Энэ үед зориудын дэлгэрэлтийг Ромын Католик чуулганаас явуулсан боловч тэднээс өмнө нь хэдийн Христитгэл дэлгэрч, тодорхой амжилтыг олчихоод байсан юм. Их Монгол Улсын нийслэл Хархорум хотод институцжэн, хэлбэржсэн Христийн сүм дуган байсан нь нэгэнт археологи

болон бичгийн сурвалжаар нотлогддог.⁷ Эзэнт гүрэнд өөрсдөөс нь өмнө хэдийнээ Христигэлтнүүд байсныг Монголоор аялсан Ромын католик санваартнууд болох Рубрук, Марко Поло, Плано Карпини нарын аяллын тэмдэглэлүүдэд өгүүлдэг. Эдгээр аялагчид тэдгээр Христийнхэнтэй нүүр тулан уулзаж байсан төдийгүй заримдаа бүр ном хаялцаж байснаа өгүүлсэн байдаг. Тэгээд ч тэдний аялал Христигэлийг зориудаар түгээхээс илүүтэй тандах, турших, тагнуулын аялал байсныг өөрсдөө хүлээн зөвшөөрдөг. Товчхондоо Их Монгол Улс байгуулагдсан цагаас эхлэн XIII-XIV зуунд Монголчуудын байгуулсан эзэнт гүрэнд Христийнхэн нэр нөлөө байсан нь тэдний ид хөгжил цэцэглэлтийн үе байсан гэж үзэж болохоор.

Юутай ч анхны дэлгэрэлт МЭVII-XIV буюу барагцаалбал 800 зууныг хамаарч байгаа тул үүнийг дэлгэрэлт гэж үзэхээс өөр аргагүй. Харин хүн амын хэдэн хувийг Христигэлийнхэн эзлэж байсныг тогтооход нэн төвөгтэй. Бараг л боломжгүй болов уу. Хэрэв ингэж чармайх аваас Их Монгол Улсын хэмжээнд гэхээсээ Юань, Цагадайн, Алтан Ордон, Хүлэгүгийн хаант улсуудын хэмжээнд тус тусад нь авч үзвэл илүү дөхөм болох талтай. Мөн энэ үед нэр бүхий Христигэлт нүүдэлч овог аймгуудаас гадна нөлөө бүхий Христигэлт түүхэн хувь хүн олонтаа тэмдэглэгдэн үлджээ. Эдгээрийн зах зухаас дурдвал Тулуйн хатан Сорхагтани бэх,⁸ Дохуз хатан,⁹ Чингай,¹⁰ Бэгтүтмиш,¹¹ Ибага-бэхи, Өбулжин, Хулан¹² гэх мэт төрийн их хатдаас эхлүүлээд төрийн томоохон түшмэд, ноёд, тэдний албатууд Христигэлтэй байжээ.¹³

Монголын эзэнт гүрний төрийн бодлогод бүх шашин шүтлэгт аядуу, хүлцэнгүй хандаж ирсэнийг бид бэлхнээ мэднэ. Тэр тусмаа уг бодлогыг зангидаж, хэрэгжүүлж байсан хаадуудаас Христийнхэнд илт талтай байсан,

7. Ханс-Георг Хюттель ба Эрдэнэбат Уламбаяр, Хар Балгас ба Хархорум: Орхоны хөндий дэх хожуу нүүдэлчдийн сурьшмал хоёр хот (Улаанбаатар: Германы Археологийн Хүрээлэн ба МУ-ын ШУА, 2009), 56-57.

8. Эзэн Чингисийн отгон хүү Тулуйн авааль эхнэр, Хэрэйдийн Тоорил вангийн зээ, Жагамбугийн охин. Тэр бол Их Монгол Улсын “Их хаад” гэж тодорхойлогддог 4 дэх их хаан Мөнх, Юань гүрнийг байгуулсан 5-р их хаан Хубилай, Перс дэх Ил хаадын улсыг байгуулсан Хүлэгү хаан, Аригбөх нарын ээж нь байсан юм.

9. Хэрэйд аймгаас гаралтай, Тулуйн бага хатан байгаад Хүлэгү хааны их хатан болсон. Армяны он дарааллын бичээст “Ариун Елена”-тай зүйрлэгдэн магтагдсан их хатан байсан.

10. Төрийн заргач, Шихихутагийн туслах төрийн томоохон зүтгэлтэн энэ хүн Жувеиний бүтээлд Христигэлт хүн байсан гэж тэмдэглэгджээ. 1206 онд Их Монгол Улс байгуулагдахад төрийн бичээчээр томилогдсон. Мөнх хааны тушаалаар төрийн үймээнд оролцсон хэргээр цаазлагдсан ч Хубилай хааны үед цагаадсан.

11. Чингисийн ууган хүү Зүчийн хатан. Хэрэйд аймгаас гаралтай.

12. Ибага-бэхи, Өбулжин, Хулан – эдгээр хатгууд Чингисийн хожим авсан хатад. Хулан хатан Мэргид аймгийнх байсан бол Ибага-бэхи, Өбулжин нар Хэрэйд аймгийнх байлаа.

13. Жувеины “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” гэсэн зохиолд төрийн их заргач Шихихутагийг Нестор итгэлт Христэч хүн байсан гэж тэмдэглэсэн байдаг боловч энэ нь бүрэн батлагдаагүй тул үүнд багтаасангүй

Христийнхнийг хамгаалж хаацайлж, дэмжиж байсан гэдгээр Араб, Персийн түүхчдийн зохиол бүтээлүүдэд тэмдэглэгдсэн хаадууд гэвээс их хаад болох Өгөөдэй, Гүюг, Мөнх нар. Мөн түүнчлэн Сартаг, Аригбөх, Хубилай, Хүлэгү, Чормаган, Байжу гэх мэт Монголын хаад, ихэс ноёдууд байна. Лалын түүхчид төдийгүй Дундад Азийн Христитгэлт түүхчид бас тэднийг Христийнхэнд талтай байсны төлөө сайшаан магтсан байх юм. Жишээ нь, Армяны түүхч Григор Агнерци бичихдээ:

“Сайн санаат Чормаган таалал төгсөв. Түүний Алтан хатнаас төрсөн хоёр хөвгүүний нэг нь Сирамун, нөгөөх нь Бора нэртэй байв. Сирамун нь ариун шударга нэгэн байв. Балчир ахуйгаасаа загалмайтнуудыг болон тэдний сүм дуганыг талархагч нэгэн байлаа. Тэр дээд эзэний тааллаар гарамгай дайчин болсон нэгэн байлаа. Хан нар түүний эрэлхэг зориг болон байгуулсан гавьяаг нь үнэлж ‘Алтан багана’ хэмээн нэрлэдэг байлаа. Харин дүү нь түүний яг эсрэг зан чанартай нэгэн бөгөөд муухай ааш зан, явдлаасаа бол Хүлэгү хааны зарлигаар хороогджээ.”¹⁴

Энд өгүүлэгдсэн Чормаган ноён нь Армянд байсан Христийнхэнд сайнаар хандсан Монгол ноён байсан юм. Энэ мэтчилэн Монголын хаад, ноёдын зүгээс Их Монгол Улс даяар эрхшээлд нь багтаж байсан болон нэмж эзлэгдсэн Христийнхэнд эелдэг сайнаар хандаж байсныг түүх нотолж байна. Гэхдээ энэ байдал салж тарсан эзэнт улсуудад харилцан адилгүй байсан юм. Ялангуяа Хүлэгүгийн хаант улсын сүүлч үеийн хаад Лалын шашинтан болсонтой холбогдуулан Бага Ази, Ойрхи Дорнод, Дунд Ази дахь дорнын Христийнхэнд асар их гай гамшиг, хавчлага дарамт учруулсан түүхтэй. Харин Алтан Ордоны хаадын хувьд тэнд байсан Оросын Үнэн алдартны сүм хийдэд ууссанаар дуусгавар болсон гээд харилцан адилгүй байсан юм. Гэхдээ энэ нь Христитгэлийн дэлгэрэлтийн анхны үеийн төгсгөлөөр болсоныг цохон тэмдэглэх нь зүйтэй буйзаа.

Христитгэлийн гол хөлгөн судар болох Библийг Монгол хэлнээ орчуулсан нь энэ үед тохиож байгаа юм. Юань гүрний нийслэл Дайдуд үйлчилж байсан Католик санваартан Монтекорвино Библиэс Дуулал номыг, зарим нэг Католик мөргөлийн хэсгээс Монгол хэлнээ орчуулсанаа тэмдэглэсэн нь бий.¹⁵ Энэ нь монгол хэл дээрх Христитгэлийн бүтээлүүдийн талаарх анхны мэдээлэл юм. Үүнээс өмнө Монгол хэл дээр орчуулагдсан байж болох ч өвлөгдөн ирсэн, тэмдэглэгдэн үлдсэн нь үгүй. Лавтайяа мэдэж буйгаар Сири бичгээс уйгурууд бичгээ авч, уйгуруудаас Монголчууд бичгээ авсан нь тодорхой.

Дээр өгүүлсэнчлэн дэлгэрэлт байсан гэдгийг нотлохуйц шалгууруудаас хүн амын хэдэн хувийг эзэлсэн эсэхийг тогтоохоос бусдыг нь энэ үе хангаж байна.

14. Григор Агнерци, Нум сумтан ард түмний түүх, орч. Д.Анхбаяр (Улаанбаатар: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, 2010), 45.

15. Bayarjargal Garamtseren, “A History of Bible Translation in Mongolian,” Bible Translator Journal, Vol. 60, №4, (UBS, 2009), 216-217.

Тиймээс, Монгол нутагт МЭVII-XIV зууныг хүртэл дэлгэрсэн Христитгэлийг “дэлгэрэлтийн анхдугаар үе” байжээ гэж бүрэн дүгнэж болохоор байна.

1.2 Оролдлогын үе буюу XVIII-XX зууны эхэн

Санал болгосон дээрх шалгууруудаар шүүвэл XVIII-XIX зууныг хоёр дахь дэлгэрэлт гэж авч үзэх боломжгүй байна. Хэдийгээр энэ үед Библийн орчуулга дээр илт дэвшил гарсан ч Монгол хүмүүсийн дунд хангалттай дэмжлэгийг авсангүй. Тиймээс энэ үеийг Христитгэлийг дэлгэрүүлэх гэж оролдсон “оролдлого”-ын үе гэж үзээд анхны болон удаах дэлгэрэлтийг холбож байгаа үе шат гэж тусгайлан авч үзлээ. Товчхондоо XVIII-XIX зууны Протестант болон Католик илгээлтийн байгууллагуудын Монголд нэвтрэн орж ирэх гэсэн оролдлого.

Моравичууд 1764 оноос Ижил мөрний хөвөөнд суурьшсан Торгуудад буюу өнөөгийн Халимагууд руу очсоноор энэ түүх эхэлдэг. Морави итгэлт Исаак Шмидт хэмээгч голланд хүн, 1809-1816 оныг хүртэл Шинэ Гэрээний дөрвөн Сайнмэдээг анх Халимаг Монгол хэлээр орчуулжээ.¹⁶

Харин “Лондонгийн Илгээлтийн Нийгэмлэг”-ээс Буриад Монголчууд руу хаант Оросын нутгаар дамжин 1817-1902 оны хооронд хийсэн үйлчлэл үүнд зайлшгүй багтана. Гол төлөөлөгчид нь Эдвард ба Сара Сталлибрас, Корнель Бетти Рамн, Жеймс Гильмор. Тэд анхлан Буриад Монгол хэлээр бүтэн Библийг орчуулсан. XIX зууны төгсгөлөөр 1936 он хүртэлх үеийн гол төлөөлөгч нь Швед хүн Франс Август Ларсон ба 1894-23 он хүртэл Монголд амьдарчээ. Мөнхүү энэ үеийн гол төлөөлөгчдийн нэг бол яах аргагүй Католик санваартан, нэрт Монгол судлаач Антоон Мостаэрт юм. Тэрээр 1905-1925 оныг хүртэл Ордост Католик сүмд ажиллаж, Монголыг сурвалжлан судалсан байдаг.¹⁷

Хэдийгээр Католик болон Протестантуудын зүгээс зориудын дэлгэрүүлэлтийг Ордос, Халимаг, Буриадад, хожим нь Нийслэл Хүрээнд хийж байсан боловч Христитгэл Монгол нутагт жигд тархан түгсэнгүй. Хүн амын тодорхой хувийг ч олигтой эзэлсэнгүй. Гэвч энэ үеийн хамгийн гол амжилт нь хүн төрөлхтний өв болсон, эрин зуунуудын турш хүмүүний түүхэнд асар их нөлөө үзүүлсэн Библийн хөлгөн судрыг Монгол хэлнээ орчуулсан явдал байв.

Энэ нь дараагийн дэлгэрэлтийг амжилттай болох гол үндсэн суурь болоод зогсоогүй XVIII-XX зууны эхэн хүртэлх Монгол хэл ба түүний үгсийн санг хадгалан үлдэх том завшаан болсон юм.

16. Библийн хөлгөн судар нь Хуучин ба Шинэ Гэрээ хэмээх хоёр үндсэн хэсгээр зааглагдсан 66 номоос бүрддэг. Хуучин Гэрээ нь Христийг төрөхөөс өмнө бичигдсэн 39 ном, Шинэ Гэрээ нь Христээс хойш буюу Христийн сүм чуулган байгуулагдсан цагаас хойш бичигдсэн 27 номоос бүрддэг. Энэхүү Шинэ Гэрээний эхний дөрвөн ном болох Матай, Марк, Лук, Иохан гэсэн номуудыг хамтад нь “Сайнмэдээний номууд” гэж нэрийддэг.

17. Г.Цэцэгдарь, Нэрт Монголч эрдэмтэн, Католик шашны санваартан Антоон Мостаэрт, Ред. Г.Цэцэгдарь (Улаанбаатар: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, 2011)

1.3 Хоёр дахь дэлгэрэлтийн үе буюу 1990 оноос эдүгээ хүртэлх

Энэ үе нь анх дурдсан үечлэлийн шалгууруудаас хоёр дахь буюу “он цагийн шалгуурыг давсан” гэдэгт тэнцэхгүй байгааг шударгаар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Гэхдээ өмнөх оролдлогын үе нь энэ дэлгэрэлтийн үеийг хангаж өгсөн, энэ үетэй шууд холбоотой гэдгийг тооцвол үүнийг цайруулж болмоор. Үүнээс өмнөх бараг гурван зууныг элээсэн “оролдлого”-ын үеийн гол амжилт нь Библийг Монгол хэлнээ орчуулсан явдал байлаа.¹⁸ Библийг Монгол хэлнээ орчуулсан явдал нь Христитгэлийн дэлгэрэлтийг эдүгээ бүрэн “дэлгэрэлт” байсан гэж хэлэхүйц хэмжээнд шууд аваачсаныг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Монголд Христийн сүм чуулганууд байгуулагдахаас өмнө Библийг хэдийнээ орчуулчихсан байсан нь нэг талаар Христитгэл 1990-2000 оны хооронд, ялангуяа хүүхэд залуучуудын дунд эрчтэй дэлгэрэхэд шууд нөлөөлсөн. Нөгөө талаар энэ нь Христитгэлийн түүхэн дэх бас нэг содон үзэгдэлд тооцогдохуйц байдгийг энд дурдвал. Аль ч улсад Христитгэл дэлгэрэхдээ эхлээд итгэгч бишрэгчтэй болоод, дараа нь сүм чуулганаа байгуулаад, Библийн болоод сүм чуулган дахь мөргөлийн үг хэллэг бүрэлдэх үетэй зэрэгцэн Библийг орчуулсан байдаг. Харин энэ удаагийн дэлгэрэлт түгээмэл энэ зүй тогтлоос эсрэг байсан нь өмнөх үеийн “дэлгэрэлтийн оролдлого”-ын үр дүн гэхээс өөр замгүй. Өөрөөр хэлбэл, итгэгч сүсэгтнүүд хийгээд сүм чуулган, тэнд ажиллаж үйлчлэх санваартан [пастор, ахлагчид], мөргөлийн үг хэллэг бий болохоос өмнө нь Библи орчуулагдсан байсан гэсэн үг. Энэ өвөрмөц байдал нь эхэн үедээ Христитгэлийг хүчтэй дэлгэрэхэд нөлөөлж байсан бол, эдүгээ Библи орчуулгын хүрээнд, заримдаа мөргөл литургийн хэмжээнд нэр томъёоны талаарх үл ойлголцол, талцал, мэтгэлцээнийг тарьж байна.

Товчхондоо бусад шалгууруудыг энэ цаг үе маань бүрэн дүүрэн хангаж байгаа тул яах аргагүй “хоёр дахь дэлгэрэлт” байжээ гэж дүгнэхээс өөр аргагүй болгож байна. (Дэлгэрэнгүйг харьцуулсан хүснэгтээс харна уу)

2. Христитгэл үү? эсвэл Христийн шашин уу?

Оршилд өгүүлсэнчлэн Христитгэлийн дэлгэрэлтийн түүх нь шинэ судалгааны асуудал, тиймээс саяхнаас эрчимтэйгээр судлагдаж ирсэнийг цухас дурдсан билээ. Шинэ тулгар судалгааны асуудал тул зарим нэг нэршлийн асуудлууд зайлшгүй гарч ирсээр байна. Энэ хүртэл уншихдаа та анзаарсан бол эхлэхээс төгсгөл хүртлээ миний бие “Христитгэл” гэсэн нэршлийг ашигласныг мэдэж болно.

Бусад судалгааны өгүүлүүдэд гол төлөв “Христийн шашин” гэж хоршоо үгээр өгүүлдэг. Эндээс Christianity [Англи], Христианство [Орос] гэдгийг Монгол хэлнээ юу гэж орчуулж ойлгох вэ? гэсэн нэршлийн асуудал урган гарч буйг өгүүлэх гэсэн юм.

18. Энх-Амгалан Пүрэвдорж, “Библийн Монгол орчуулгын товч түүх,” Пасторын өчил I (Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2013), 91-94.

Христитгэл үү? эсвэл Христийн шашин уу? Зарчмын хувьд энэ хоёрын хооронд бараг ялгаагүй юм шиг. Гэвч нэгдсэн ойлголтыг өгүүлж чадах уу? гэдэг дээр асуудал тулгарна.

Үүнийг өгүүлэгч нь “Христитгэл” гэдгийг баримтлах болсон шалтгаан гэвэл сүүлийн хэдэн жилээс Христийнхэн өөрсдөдөө “Христитгэл” гэдгийг оноотуулан нэрлэж буйд оршино. Ялангуяа нэлээн консерватив Христийнхэн “шашин” гэдэг үгнээс бүр анхнаасаа нэлээдгүй цэрэвсээр ирсэн. Тэд Христитгэлийг [Christianity]-г шашин биш, харин хувь хүний итгэл үнэмшил, хүмүүний бүтээгч Бурханд итгэн сүсэглэх сүсэг бишрэл гэдгээр тайлбарладаг. Ингэхдээ “Христийн шашин” гэдгийг үл итгэгчдийн өгсөн нэр томъёолол гэж үздэг.

Байдал ийм байгаа тул, судалж буй объективд маань буй судлагдаж буй субъектүүд маань өөрсдийгөө юу гэж ойлгож, юу гэж тодорхойлж, тийнхүү оноон нэрлэж буй нэршлийг баримталлаа.

3. Несторчууд уу? эсвэл Эрхүүд үү?

Дараагийн нэршлийн асуудал бол Анхны дэлгэрэлтийн үеийн Христийнхнийг юу гэж нэрлэх вэ? гэдэг асуудал. Өнөөдрийг хүртэлх Монгол дахь Христитгэлийн түүхийн бүтээлүүдэд үргэлж “Несторчууд, Несторианчууд, Несторынхон” гэх мэтээр нэрийдсээр ирлээ. Гэвч үнэхээр тэднийг “Несторчууд” гэж хэлэх нь зөв үү? гэдэгт эргэлзмээр байдаг. Үүнийг Нестор ба түүний шавь нарын түүхэн үүсэл, уг сурвалж өөрөө няцаадаг. Ийм байхад өнөөг хүртэл энэ үеийн Христийнхнийг “Несторчууд” байсан гэж нэрлэсээр буй нь гайхмаар. Угтаа бол энэ нь бараг доромж үг. Өрнийн чуулган (Ром төвтэй Католик сүм)-аас бүх Дорнын чуулганыг тэрслүү, гаж, зөрүүд гэдгийг товчлон хочилсон нэршил бол энэхүү “Несторчууд” гэсэн нэршил болой. Энэ тухай АНУ-ын Монгол судлаач, доктор профессор Христофер Этвүүд өгүүлэхдээ:

“Эрт үед Монголд нөлөөлсөн нөлөөллийг нь эс тооцвол, Христитгэл нь Монголын эзэнт гүрэнд хэзээ ч оройлж байсангүй, эзэнт улс задрахтай зэрэгцээд Дотоод Азидаа сураггүй болсон юм. Монголын эзэнт гүрний бүс нутагт хэд хэдэн Христийн чуулганууд багтаж байснаас: Гүржийн, Оссетын (Аланчууд), Оросын Үнэн алдартны салбар болох Зүүн Ортодокс Чуулган, Армяндын Элчийн эрхэт чуулган, гадныхнаас ‘Несторчууд’ гэж нэрлэгдсэн Зүүний Ассирийн чуулган болно. Сүүлд нэрлэгдсэн чуулганы хувьд гэвэл тэд Багдад төвлөрч, өөрсдийн мөргөл дэг жаягд (литург) Сири хэлийг хэрэглэж байсан бөгөөд эртнээс Төв Азид Христитгэлийг дэлгэрүүлж байсан юм. Тэр дундаа Буддистууд зонхилсон Турфаны Уйгуруудад Христитгэлийг нэлээн далайцтай дэлгэрүүлжээ.”¹⁹

Христофер Этвүүдийн дээр онцолсон “гадныхан” гэдэг нь Ватикан төвтэй Ромын Католик болон хожим тэднээс салбарлан бие даасан Протестант чуулгануудыг хэлж буй хэрэг юм.

19. Christopher P. Atwood, “Christianity in the Mongol Empire,” *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire* (Bloomington: Indiana University, 2004), 107.

Уг нэршлийн асуудлыг нэлээн чамбай хөндсөн хүний нэг бол яах аргагүй Цаллинг Х.Ф. Халберцма юм. Түүний нотолж буйгаар энэ нь Их Монгол Улсаар аялсан Католик санваартан Рубрук, Жон Монтекорвино нарын тийнхүү нэрлэсэн явдлаас үүдэлтэй аж. Тэдний хувьд “Нестор” гэж оноохын учир нь Ромын католик сүмээс ангид, тэрслүү Христитгэл гэдгээр ашиглагдсан томъёолол байжээ.²⁰ Тэрээр Нестор ба түүний шавь нарын Азийн чуулгануудад нөлөөлсөн нөлөөллийг дүгнэж:

“Зүүний чуулган нь Несторыг ‘Грекийн гурван гол сэтгэгчид’-ийн нэг гэж үнэлдэг ч ‘Несторын чуулган’ гэж ахин дахин оноон нэрлүүлээд буй Христэч уламжлалыг нотлохуйц өндөр хэргэм зэргийг [бишоп] түүнд соёрхож байгаагүй юм. Үнэндээ, Зүүний чуулган Нестороор байгуулагдаагүй, түүний онол сургаалын нөлөөнд ч автаагүй, тэр үедээ ч тэд өөрсдийгөө ‘Несторын чуулганыхан’ гэж оноон нэрлэж байгаагүй юм” гэсэн байна.²¹

Энд өгүүлсэнчлэн үнэхээр Эзэнт гүрний үеийн болоод түүнээс өмнөх үеийн Христийнхэн өөрсдийгөө “Несторынхон” гэж нэрлэж байгаагүй. Харин тэд өөрсдийгөө Монгол хэлнээ “Эрхүүд” гэж оноон нэрлэсээр иржээ. Иймээс, судлаачийн хувьд энэ үеийн Христэчдийг “Несторчууд” гэхийн оронд, өөрсдийгөө нэрлэж байсан “Эрхүүд” гэсэн нэршлээр нь дуудаж занших нь зөв гэж үзэж байна.²² Эсвэл “Зүүний [Дорнын] Чуулган”-ын Христийнхэн гэвэл зохистой санагдана.

Цаашид эдгээр нэршлийн асуудлууд нээлттэй байгаа бөгөөд ялангуяа шашин судлаачид, түүхчдийн хувьд алийг нь баримтлахаа ойрын хугацаанд шийдэх бизээ.

Abstract: The expansion of the Christianity in Mongolia is one of the recent and controversial topics of modern Mongolian History. This research note refers to few periods of expansion of Christianity. The research note shows that Christianity expanded into Mongolia through two main periods (AD VII-XIV and after Democratic Revolution in 1990) and one attempting period (XVIII-XX first half). First Christians had been visited to Mongolia since AD VII and they were not Nestorians. They were from East Church of Assyria, but today they are called “Nestorians” paradoxically.

20. Tjalling H.F. Halbertsma, Early Christian Remains of Inner Mongolia: Discovery, Reconstruction and Appropriation, BRILL Volume 88 (Leiden: Brill, 2008), 5.

21. Мөн тэнд., 5.

22. У.Эрдэнэбат, Дундад зууны Монгол оронд загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс (Улаанбаатар: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, 2009), 29-34.

Номзүй

- Агнерци, Григор. Нум сумтан ард түмний түүх, орч. Д.Анхбаяр.
Улаанбаатар: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, 2010.
- Болдбаатар, Чунт ба Мөнх-Очир, Доржжүгдэр. “Монголын ойрхи үеийн түүхийн үечлэлийн асуудалд,” Хэцүү өрөг, уран нүүдэл: Монголын түүхийн сэдвүүд. Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2011 16-24
- И Со Гинь, Монголын Христитгэлийн түүх, Хичээлийн материал. Улаанбаатар: InterCP, 2010.
- Монгол Улсын Үндэсийн Статистикийн Хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүн.
- Пүрэвдорж Жамсран, “Орчин үеийн соёлын болон шашны төрх: Сүүлийн 20 жилд Монголд хөгжсөн Христийн шашны хөгжил,” Социализмын дараах Монголчууд: улс төр, эдийн засаг, шашин. Ред. Брюс М. Кнауфт, Ричард Таупиер. Улаанбаатар: Адмон, 2012, 143-151.
- Сэрдарам, Д. “Монгол дахь Христийн шашны дэлгэрэлтийн түүхийн асуудал: орчин үеийн жишээн дээр” Монгол дахь шашны судалгааны өнөөгийн нөхцөл байдал. Ред. Л.Алтанзаяа. Улаанбаатар: МУБИХ, 2008, 14-20.
- Ханс-Георг Хюттель ба Эрдэнэбат, Уламбаяр. Хар Балгас ба Хархорум: Орхоны хөндий дэх хожуу нүүдэлчдийн сурьшмал хоёр хот. Улаанбаатар: Германы Археологийн Хүрээлэн ба МУ-ын ШУА, 2009.
- Хью Кемп, Түүхийн балархай жимээр. Улаанбаатар: МТӨС, 2009.
- Цэцэгдарь, Г. Нэрт Монголч эрдэмтэн, Католик шашны санваартан Антоон Мостаэрт. Ред. Г.Цэцэгдарь. Улаанбаатар: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, 2011.
- Энх-Амгалан, Пүрэвдорж. “Библийн Монгол орчуулгын товч түүх,” Пасторын өчил I. Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2013, 91-94.
- Эрдэнэбат, Уламбаяр. Дундад зууны Монгол оронд загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс. Улаанбаатар: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, 2009, 29-34.
- Bayarjargal Garamtseren, “A History of Bible Translation in Mongolian,” *Bible Translator Journal*, Vol. 60, №4. New Zealand: UBS, 2009. p 215-233. Christopher P. Atwood, “Christianity in the Mongol Empire,” *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*. Bloomington: Indiana University, 2004. p 107-109.
- Tjaliing H.F. Halbertsma, *Early Christian Remains of Inner Mongolia: Discovery, Reconstruction and Appropriation*, BRILL Volume 88. Leider Brill, 2008.

Харьцуулсан хүснэгт

Үечлэх шалгуурууд	МЭVII-XIV	XVIII-XX зууны эхэн	1990 оноос хойш
Гаднаас буюу хилийн чанадаас зориудын дэлгэрүүлэлтийг [илгээлт] хийсэн эсэх	- МЭVII-VIII зуунд Торгоны замаар, Хятадын гүнээс Христийнхэн ирсэн, - XIII зуунд Ромын католик сүм хийдээс санваартнууд явуулсан	- Моравичуудын Халимаг дахь илгээлт - Лондонгийн Илгээлтийн нийгэмлэгийн Буриад дахь илгээлт - Ордос дахь Католик илгээлт гм	- Монголд Протестантын бараг бүх урсгал чиглэлүүдээс, Ромын Католик сүмээс илгээлт хийсэн - Гадны илгээлтийн ихэнх хэсгийг БНСУ-ын Пресветериан сүмийнхэн эзлэж байна
Тодорхой түүхэн урт он жилүүдийг элээсэн эсэх	- Барагцаалбал 800 орчим жилийг хамаарч байна	- Хоёр зууныг хамаарч байна	- Одоогоор 20 орчим жил л болж байна
Монгол хэл дээр ном судраа орчуулан хэрэглэж байсан, урлаг соёл, ахуй соёл, зан заншилд нь Христитгэлийн үзэл санаа тусгалаа олсон эсэх	- Монтекорвино Дайду хотод байхдаа Библийн Дуулал номыг орчуулж байснаа дурдсан	- Энэ үеийн хамгийн гол ололт нь Халимаг, Буриад Монгол хэл дээр Библийг орчуулсан явдал болно	- Библийг бүтнээр нь орчин цагийн Монгол хэл дээр орчуулсан - Христитгэлт бүх төрлийн ном хэвлэл нийтлэгдсэн - Христитгэлт дуу шүлэг, уран зураг гм утга зохиол, соёлын бүх хэлбэрээр Христитгэл таниулагдаж байна
Төр засгийн зүгээс Христитгэлийн талаар тусгайлан эерэг болон сөрөг бодлого явуулсан, хууль цааз тогтоосон эсэх	- Монголын их бага хаадууд бүх шашинт хүлцэнгүй хандаж байсны адилаар хандаж байсан - Зарим нэр бүхий хаад Христийнхэнд илт талтай хандаж байв - Дэлгэрэлтийн төгсгөлөөр зарим бүс нутагт Христийнхэнд хатуу хандсан	- Буддист шашинт Монголчуудын зүгээс нэлээн хаалттай, сэжиглэнгүй хандсаар ирсэн - Ялангуяа Оросын Үнэн алдартны сүмээр төсөөлж байсан тул харийн, булаан эзлэгчдийн шашин гэдгээр ойлгогдож байв	- 1990 оны Үндсэн хуулинд “хүн шашин шүтэх, эс шүтэх” эрхтэй гэж хуульчлан хамгаалсан - 1992 оны Төр ба сүм хийдийн харилцааны хуулиар Христийнхний төртэй харилцааг хуульчилсан. - Уг хуульд “шашин нь төрөө дээдэлж, төр нь шашнаа хүндэлнэ” гэж үндсэн харилцааг томъёолсон

Хүн амын годорхой хувийг ээлсэн эсэх		- Зөвхөн Торгууд, Буриад гм Монголын зарим нэг овогт Христитгэл дэлгэрэх гэж оролдсон - Маш цөөхөн хүн хүлээн авсан - Ордост байсан Католик санваартан Антоон Мостаартын үйлчлэлээр 1000 орчим Монгол хүнийг Христэд итгэгчид гэсэн нь хамгийн өндөр тоо	- 2010 оны хүн амын тооллогоор 41,117 буюу 2,1% гэж гарсан
Христитгэлийг хүлээн авсан, гухайн үедээ хүлээн зөвшөөрөгдөж чадсан түүхэн биет хүн, гөлөөлөгчид байсан эсэх	- Нэлээн хэдэн Хэрэйд, Мэргид, Онгуд гэх мэт овог аймгаас гауралтай нэр бүхий хатдууд, өндөр алба хашиж байсан ноёд, язгууртнууд байсан	- Зарим нэг цөөн хэдэн Торгууд, Өвөрлөгч, Буриад хувь хүний нэрийг тэмдэглэн үлдээсэн	- Нийгмийн бүх анги давхар, бүх насны хүмүүсийг хамаарч байна - Нийгэмд танигдсан яруу найрагчид, улс төрч, жүжигчид, багш сэхээтэн гм нэр бүхий хүмүүс байна
Гухайн түүхэн оршин байсан улс гүрнийхээ хил хязгаарынхаа хүрээнд газар бүрт жигд тархсан байсан эсэх	- Их Монгол Улсын бүрэлдэхүүнд Ромын католик чуулганаас бусад бараг бүх Азийн чуулганууд багтаж байсан	- Өвөрмонголд Ордост, Европод Халимагуудад, хойшоо Буриадад гм хэсэг бусад газрыг хамаарч байлаа - Нийт Монгол нутаг болон хүн амын бүхэлд нь хамаарч байгаагүй	- Өнөөгийн Монгол Улсын засаг захиргааны хуваарийн дагуу 21 аймаг, УБ, Эрдэнэт, Дархан хотуудад ойролцоогоор 500 гаруй сүм чуулган байгаа гэж үзэж байна - Аймгуудаас Баян-Өлгийд 2 сүм байгаа нь хамгийн багад нь тооцогдож байна